

**АРХАНГАЙ АЙМАГТ 5 ГА ТАЛБАЙД
МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР БАЙГУУЛАХ,
ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ**

Төслийн нэр: Иж бүрэн тоног төхөөрөмж бүхий механикжсан “МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР” байгуулж ашиглалтад оруулах, цаашдын үйл ажиллагаа явуулах

Төслийн байршил: Архангай аймаг

Төслийн хүчин чадал: Жилд 1,500,000 (нэг сая таван зуун мянган) ширхэг шилмүүст, жимсний мод, бут сөөг, навчит болон бусад байгалийн ургамлын тарьц суулгац бэлтгэн нийлүүлэх

Архангай аймагт байгуулах “МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР” нь доорх талбайн дэд хэсгүүд, байгууламжуудаас бүрдсэн байх бөгөөд жагсаалтанд оруулсан мэдээллээр хязгаарлагдахгүй.

Хүснэгт 1. МҮГ-т шаардагдах байгууламж, дэд хэсгүүд

Д/д	МҮГ-ын талбайн дэд хэсэг, байгууламж
1	Хашаа, Хамгаалалтын ойн зурвас
2	Хүлэмжийн хэсэг (бортоготой)
3	Шинэс үрээр үржүүлэх талбай
4	Гацуур үрээр үржүүлэх талбай
5	Улиас мөчрөөр үржүүлэх талбай
6	Бургас мөчрөөр үржүүлэх талбай
7	Хайлаас болон бусад навчит төрлийн мод сөөг үрээр үржүүлэх талбай
8	МҮГ-ын оффис
9	Ариун цэврийн эко байгууламж
10	Аж ахуйн хэсэг
11	Тарьц, суулгацыг түр хугацаанд хадгалах сэрүүн зоорь
12	Худаг, нөөцийн сав, усалгааны систем
13	Тоног, төхөөрөмжийг хадгалах-гарааш
14	Зам, талбайн тохижилт

Хүснэгт 2. Оюу Толгой ХХК-иас нийлүүлэх тоног төхөөрөмжийн урьдчилсан жагсаалт

Д/д	Техник, тоног төхөөрөмжийн нэр, зураг	Зориулалт
1	Трактор	Мод үржүүлэг, Ойн аж ахуй ХАА-н зориулалттай төрөл бүрийн агрегатыг угсарч хөрс хагалах, боловсруулах, үрлэх, хураах болон тээвэрлэх зэрэг олон ажлыг гүйцэтгэнэ.
2	Хошуут анжис-4 корпуст	Атар болон боловсруулсан газрын хагалах ба дараагийн шатны боловсруулалтын техникүүд явах нөхцлийг бүрдүүлнэ.
3	Роторт сийрүүлэгч	Роторт сийрүүлэгч нь 5-30 см хүртэлх ажлын гүнд ашиглах боломжтой бөгөөд ургамлын үлдэгдлийг жигд боловсруулж, хөрсийг сийрүүлэхэд хамгийн тохиромжтой. Таримлын үндэсний систем үүсч хөгждөг хөрсийг сийрүүлэх, агааржуулах нь арвин ургац авах тун аятай нөхцөл бүрдүүлдэг
4	Культиватор	Олон үйлдэлт хөдөлгүүрт их бие нь дагалдах төхөөрөмжүүдээ ашиглан хөрсийг хагалах, сийрүүлэн бутлах, өргөн болон зурвас далан гаргах, хөрсийн нийлэг хальсаар хучих гэх мэт ажилбаруудыг хийж гүйцэтгэдэг.
5	4 үйлдэлт урд шанага	Мод үржүүлгийн газарт газар шорооны ажил хийхэд
6	Сэрээт өргөгч	Мод үржүүлгийн газар өргөж зөөх ажил хийхэд
7	Чулууны шанага	Мод үржүүлгийн талбайн хайрга чулууг түүж авах ажилд ашиглана
8	Цахилгаан сэрээт өргөгч	Хүлэмжинд үрсэлгээний тавцангууд зөөвөрлөх
9	Чиргүүл	Тарьц, суулгац, хөрс, бордоо тээвэрлэх
10	Бага оврын ачааны машин	Тарьц, суулгац, хөрс, бордоо тээвэрлэх Ажилчид тээвэрлэх, бараа материал болон аж ахуйд тогтмол ашиглах
11	Үрлэгч СЛУ-5-9	Үр тарих
12	Хөрс сийрүүлэгч КМС-2У	Хөрс сийрүүлэх
13	Үндэс хавагч ПК-1,2	Үндэс хавах
14	Нүх ухагч	Мод тарих нүх ухах
15	Тарьц ухагч	МҮГ-ийн талбайд ургуулсан тарьц, суулгацыг ухаж авах
16	Бортого дүүргэгч	Бортогонд хөрсний холимогийг ижил хэмжээтэй дүүргэх
17	Гар үрлэгч	Ил талбайд үр тарихад үрийн норм болон гүн тохируулж өгөх
18	Моторт нүх ухагч	Хамгаалалтын зурвас болон бусад төрлийн нүх ухах давуу талууд: Хөдөлмөрийг өндөр хэмжээнд хөнгөвчилнө Хэрэглэхэд хялбар Хөнгөн авсаархан хаана ч хэрэглэх боломжтой
19	Усны насос	нөөц
20	Цахилгаан мотор	Нөөц байдлаар ашиглана. Цахилгаан тасарсан тохиолдолд
21	Шингэн бордоо хадгалах сав	МҮГ-ын хөрс бордох шингэн бордоо нөөцлөх, бордоо найруулах
22	Үрсэлгээний тавцан	Бортоготой тарьц суулгацыг ургуулахад